



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
E-mail: dundgov@audit.gov.mn

2020.07.30 № 118

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

АРДЧИЛСАН НАМЫН ДУНДГОВЬ  
АЙМГИЙН ЛУУС СУМЫН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Луус сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Луус сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Луус сумын Ардчилсан нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Луус сумын Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр / ..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Луус сумын сонгуулийн хороонд

Хавсралт . . . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ТӨВСАНАА

0012020433

АРДЧИЛСАН НАМ

Луус сумын Ардчилсан Намын Хорооны  
2020 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн  
хурлаар хэлэлцэж батлав.

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН  
ХОРОО

8198916 XHT1000



ЛУУС СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

---

*Ramir*

## НЭГ. ИРГЭН БҮР ЭРҮҮЛ СУМ

- 1.1 Иргэн бүрийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.2 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулна
- 1.3 Эко сумын төв болгох зорилт тавин ажиллана
- 1.4 Уламжлалт анааах ухааны төвийн үйл ажиллагааг дэмжиж, гадаад дотоодын эмч нартай хамтран ажиллаж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хуртээмжийг сайжруулах замаар сэргээн засах тусlamж үйлчилгээг өргөжүүлнэ.
- 1.5 Эхчүүд эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуйн чиглэлээр “Эхчүүдийн сувилал”-ийг хувийн хэвшил, төрийн оролцоотойгоор байгуулна.
- 1.6 Сумын эмнэлгийн алсын зайн оношилгооны техник хэрэгслээр хангаж цахим харилцаа, цахим оношилгоо хийх боломжийг бүрдүүлэн, гурав дахь шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэн эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь мэргэшүүлэн иргэдэд үзүүлэх тусlamж үйлчилгээг сайжруулна.
- 1.7 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв” болон “Ахмадын байгууллагууд”-ын үйл ажиллагааг сумдын орлого бүхий хөрөнгө оруулалтын үр өгөөжөөр санхүүжүүлэх тогтолцоог бий болгоно.
- 1.8 Сумын эмнэлгийн сул орны боломжид тулгуурлан хүүхдийн болон ахмадын “Эмчилгээний дараах сувилахуйн болон нөхөн сэргээх төрөлжсөн сувилал”-ыг байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг бүх талаар дэмжин хамтран ажиллана.
- 1.9 “Эрүүл өсөлт” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ

## ХОЁР. ИРГЭД НЬ ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ СУМ

- 2.1 Багш, удирдах ажилтны мэргэшлийг дээшлүүлж, боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 2.2 Иргэдийн цахим боловсролыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, программ болон техник хангамжийн чиглэлийн мэргэжилтэй ажилтны нөөцийг бүрдүүлж, цахим үйлчилгээ үзүүлдэг иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийг дэмжинэ.



**ГУРАВ. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БА СОЁЛ, СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

- 3.1 Сумын төв болон хөдөөгийн иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлтэй сууцанд амьдрах боломжийг бий болгоно.
- 3.2 Иргэдийн хуримтлал үүсгэх дадлыг бий болгохын тулд "Хүртээмжтэй хуваарилалт- Хуримтлалтай иргэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 3.3 Хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг байгуулан, Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэх иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг онцгойлон дэмжиж орчин үеийн шаардлага, олон улсын жишигт хүргэхэд хамтран ажиллана.
- 3.4 Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвийг байгуулна.
- 3.5 Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, шаардлага хангасан чанартай тоног төхөөрөмжөөр хангана
- 3.6 Усан оргилууртай амралт зугаалгын томоохон талбайг бий болгоно.
- 3.7 Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна
- 3.8 Нийтийн биеийн тамирыг бүх шатанд хөгжүүлнэ.
- 3.9 Үндэсний болон багийн спорт клубуудыг дэмжих бодлого баримтална

**ДӨРӨВ. ИРГЭД НЬ АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ, АМЬЖИРГААТАЙ СУМ**

- 4.1 "Мэдээлэлжсэн нийгэм"-ийг хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ
- 4.2 Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг байгуулахыг дэмжиж ажиллана."
- 4.3 Max махан бүтээгдэхүүн ангилан ялгах, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг үйлдвэрийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулан ажиллуулна.
- 4.4 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо-техникичдийг бодлогоор дэмжин хөдөө орон нутагт ажиллуулна.
- 4.5 Малын гоц халдварт, халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, эрсдэл бүхий бүс нутгийн малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, мал сүргийг бүрэн вакцинжуулж, тайван бүсийг бий болгох арга хэмжээг тогтмол авч ажиллана.
- 4.6 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.



- 4.7 Мал аж ахуйн байгалийн гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, мал сүргийн тогтвортой өсөлтийг хангана.
- 4.8 Сумын хөдөөгийн баг бүрд мал угаах “ванн” бүхий шаардлагатай орчин үеийн угаалгын цэгийг ОНХС, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр байгуулна

## ТАВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО

- 5.1 Нүүдэлчдийн ахуй онцлогийг харуулсан аялал жуулчлалын "Малчин" хөтөлбөрийг боловсруулан малчин өрхүүдээ хамруулна

## ЗУРГАА. ИРГЭД НЬ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЗАСАГЛАЛ НЬ АРДЧИЛСАН СУМ

6.1 Сумын газар нутгийн хил хязгаарыг шинэчлэн баталгаажуулах ажлыг УИХ, Засгийн газартай хамтран хэрэгжүүлж газар нутгийн маргаантай байдлыг арилгах нөхцөлийг бүрдүүлж ажиллана

6.2 Орон нутгийнхаа онцлогт тохирсон иргэддээ ил тод нээлттэй, хүнд сурталгүй шуурхай, чанартай, иргэндээ чиглэсэн үйлчилгээг нэвтрүүлж, хүнд сурталгүй, нээлттэй төрийн үйлчилгээг бий болгоно.

6.3 Удирдлагын хариуцлагыг тооцох цогц арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлнэ.

6.4 Орон нутгийн хөгжлийн сангийн 3-5 хувийг Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн бодитой үр дүнд хүрэхүйц гэрээг хэрэгжүүлэхэд зарцуулдаг болгоно.

6.5 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, шилэн болгоно. Худалдан авах ажиллагааг тодорхой зарлах, шалгаруулалтыг хуульд нийцүүлэн, шалгаруулалтын үйл ажиллагааг ямар шалгуураар хэрхэн дүгнэж байгааг олон нийтэд ил тодоор хүргэж байна

6.6 “Орон нутгийн хөгжлийн сан”-д иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

## ДОЛОО. ОРЧИН НЬ АМАР ТАЙВАН АЮУЛГҮЙ СУМ

7.1 Камержуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж, төв цэгээс нэгдсэн байдлаар хянадаг болох боломжийг бүрдүүлнэ.

7.2 Бичил болон уул уурхайн бизнес эрхлэгчдийн байгаль орчинд халгүй, аюулгүй технологи нэвтрүүлэн ажиллуулах тогтолцоог нэгдсэн бодлогоор зохицуулан ажиллуулна.

7.3 Үндны ус цэвэршүүлэх, бохир ус цэвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлнэ

7.4 Сумын төвд хог ангилан ялгах, дахин боловсруулах, булшлах шинэлэг арга технологийг нэвтрүүлнэ

## НАЙМ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



- 8.1 Нийтийн халуун усны газар байгуулна
- 8.2 Хүүхэд залуучуудын спортын төвийг бий болгоно.
- 8.3 Нийтийн ахуй үйлчилгээний төвийг байгуулна.

### ЛУУС НУТАГ МИНЬ ҮҮРД МАНДАН БАДРАГ

Мөрийн хөтөлбөр бэлтгэсэн: Ардчилсан намын Дундговь аймгийн Луус сумын хороо-г төлөөлж

Нам /эвсэл/-ын нэр

(тэмдэг) Дундговь аймгийн Луус сумын Ардчилсан намын дарга  
-ыг төлөөлж

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СҮМҮН  
ГАРЫН ҮСЭГ   
Овог нэр /Баасанжавын Өлзийхишиг/  
8488916 XHT1000

2020 оны 06 дугаар сарын 22 16:00 цаг



